




ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Улаанбаатар хот

№ ..

2024 оны 04 сарын 01

Нэг талаас "Мөнхийн хүндлэл" ХХК /РД:5147298/, түүнийг төлөөлж Ерөнхий менежер Б.Энхчимэг /цаашид "худалдагч" гэх/, нөгөө талаас "Завхан аймгийн УЦУОШТ" /РД:9039066/, түүнийг төлөөлж Завхан аймгийн УЦУОШТ дарга Э.Мөнгөнцэцэг /цаашид "худалдан авагч" гэх, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Монгол улсын иргэний хуулийн 243-261 дүгээр зүйлд заасныг үндэслэн дараах нөхцлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг /цаашид "гэрээ" гэх/ байгуулав.

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү гэрээний зорилго нь: Худалдагч тал чанарын шаардлага хангасан /смарт био00 2 ш, 24 литрийн био жорлон 7ш, био00-ийн бохирын сав 7ш, 19 литрийн угаалтуур 7ш, угаалтуурын бохирын сав 7ш, 66 литрийн угаалтуур 1ш, бохир задлаж, үнэр дарагч бодис 21ш, /цаашид "бараа материал" гэх/ нийлүүлэлтийг тохиролцсон хугацаанд Худалдан авагчид нийлүүлэх, худалдан авагч нь бараа материалаа хугацаанд нь шалган хүлээн авах, гэрээний дагуу барааны төлбөрийг бүрэн барагдуулж, хоёр талын үйл ажиллагаанд хүндрэл учруулахгүйгээр харилцан хүлээх үүрэг хариуцлагыг тогтоон хамтран ажиллахад энэхүү гэрээний ач холбогдол оршино.

Хоёр. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨР ТӨЛӨХ НӨХЦӨЛ

2.1 Бараа бүтээгдэхүүний нийт үнэ: 16.019.300 / Арван зургаан сая арван есөн мянга гурван зуун төгрөг / үсгээр бичсэн байна.

2.2 Худалдан авагч барааны төлбөрийг "Мөнхийн Хүндлэл"ХХК-ны Хаан банканд байрлах 5128031915 тоот дансанд шилжүүлнэ.



2.3 Худалдан авагч барааны төлбөрийг шилжүүлсэн тухайгаа Худалдагчид ажлын 1 хоногийн дотор мэдэгдэнэ.

Гурав. ХУДАЛДАН АВАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Худалдан авагч нь чанар, стандартын шаардлагыг бүрэн хангасан, доголдолгүй, үндсэн зориулалтын шинж чанараа алдаагүй, гэрээнд тусгагдсан нөхцлийг бүрэн хангасан бараа материалыг тохиролцсон хугацаанд хүлээж авах эрхтэй.

3.2. Бараа материалын төлбөрийг гэрээнд заасан хугацаа, нөхцлийн дагуу шилжүүлэх үүрэгтэй.

3.3. Худалдан авсан барааг шалгах болон ашиглах явцад илэрсэн доголдлыг худалдагчид 2 хоногийн дотор мэдэгдэнэ.

3.4. Худалдан авагч тал нь худалдагч талаас нийлүүлсэн барааг хүлээн авснаас хойш бараа бүтээгдэхүүний хадгалах, хамгаалахтай холбоотой болон бусад зүйлсийг захиалагч тал өөрөө хариуцна.

Дөрөв. ХУДАЛДАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Худалдан авагч нь чанар, стандартын шаардлагыг бүрэн хангасан, доголдолгүй, үндсэн зориулалтын шинж чанараа алдаагүй, гэрээнд тусгагдсан нөхцлийг бүрэн хангасан бараа материалыг тохиролцсон хугацаанд нийлүүлэх үүрэгтэй.

4.2 Худалдан авагчаас бараа материалын үнийг төлөхийг шаардах эрхтэй.

4.3. Худалдан авагч нь гэрээнд заасан үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд барааны нийлүүлэлтийг зогсоох эрхтэй.

Тав. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

5.1. Талуудын хооронд гэрээтэй холбогдож гарч болох маргааныг завшилцөл болон албан бус хэлэлцээрээр шийдэхийг эрмэлзэнэ.

5.2. Дээрх хэлэлцээр тодорхой хугацааны дараа үргэлжлэхэд гэрээний маргааныг талууд шийдэж чадахгүй бол аль ч тал шүүхэд хандах замаар асуудлыг шийдвэрлүүлэх эрхтэй.

Зургаа. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

6.1. Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэнээс



захиалагч, эсхүл нийлүүлэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол гүйцэтгэх хугацааг сунгаж болно.

6.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд талууд нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар нэн дариу бичгээр мэдэгдэнэ. Энэ тохиолдолд шаардлагатай арга хэмжээг авах бөгөөд гэрээний үйлчлэлийг бүрэн болон хэсэгчлэн зогсоож болно.

Долоо. ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙГ ШИЛЖҮҮЛЭХ

7.1. Ямар ч тохиолдолд гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

Найм. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

8.1 Энэхүү гэрээ нь Монгол хэл дээр 2 эх хувь байх бөгөөд хоёр талын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, дугаар авч, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

8.2 Талууд харилцан тохиролцож энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.
ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ БҮХ ЗҮЙЛ ЗААЛТТАЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН
БӨГӨӨД ЯМАР НЭГЭН МАРГААНГҮЙ БОЛОХЫГ БАТЛАВ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"Мөнхийн Хүндлэл" ХХК-ийн Менежер


Б. Энхчимэг/
Тамга

Утас: 94047055, 89850181
Хаяг: БЗД 22-р хороо
Доржийн гудамж 176 а
www.bio00.mn
eni0181@yahoo.com

ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Завхан аймгийн УЦХОШТ-ийн


Нягтлан бодол
Б. Ням-Осор/
Тамга

Утас: 94009292
Хаяг: Завхан, Улиастай, Өлзийт баг